



СЭЛЭНГЭ АЙМАГ
ОРХОНТУУЛ СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2017 оны 04 сарын 19 өдөр

Дугаар 23

Баянцогт

Г

Г

Соёлч өрх шалгаруулах журам
батлах тухай

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017-2020 оны стратеги төлөвлөгөөний 4.2.1 дэх хэсэг, сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.4.24 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 5-р хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Соёлч өрх шалгаруулах журмыг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү журмын биелэлтийг жил бүрийн эцэст сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлagnаж байхыг сумын Засаг дарга /П.Батбаатар/-д үүрэг болгосугай.



Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017.04.19-ний
өдрийн 5-р хуралдааны 13 тоот тогтоолын хавсралт



ОРХОНТУУЛ СУМЫН “СОЁЛЧ ӨРХ” ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл:

1.1 Өнөөгийн байдал:

Тус сум нь нийт 1008 өрхтэй. Үүнээс: Шар-Усны 1-р баг 468, Баянцогт 2-р баг 368, Хонгор-Овоо 3-р баг 172 өрхтэй. Амьдарч буй байршилаар нь авч үзвэл:

- Орон сууцны хороололд - 158 өрх
- Гэр хороололд - 443 өрх
- Хөдөө - 407 өрх

1.2 Журмыг боловсруулж, хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага:

Сумын Нутгийн захиргааны байгууллага нь нийгмийн хариушлагын хүрээнд:

- Сум орон нутгийнхаа ирээдүй болсон өрх, гэр бүлүүдийн ажиллаж амьдрах орчны тохижилтыг сайжруулах,
- Одоогийн байгаа орон сууцнуудын барилга байгууламж, хөдөө, гэр хорооллын хашаа, гаднах үзэмжийг сайжруулах,
- Иргэдээ аюулгүй, таатай цэвэр орчинд амьдруулах,
- Өнөөдөр бидний өмнө тулгараад байгаа хүн, малын гоц халдварт өвчин гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор “Соёлч өрх” шалгаруулах журмыг боловсруулан хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага урган гарч байна.

Хоёр. Энэхүү журмын зорилго:

2.1. Сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.4.24 зорилтыг хэрэгжүүлж, иргэдийн нийгмийн идэвхтэй оролцоог дээшлүүлэх замаар амьдарч буй орчин тойрноо цэвэр, эрүүл аюулгүй, өнгө үзэмжтэй байлгахад иргэдийг идэвхжүүлэх сумын өнгө үзэмж, тохижилтыг сайжруулахад энэхүү журмын зорилго оршино.

Гурав. “Соёлч өрх” шалгаруулах шалгуур үзүүлэлтүүд:

3.1. “Соёлч өрх”-ийг гэр хороолол, хөдөөний өрхүүдээр ангилан жил бүр шалгаруулна. Харин орон сууцны хорооллын хувьд орцоор нь шалгаруулах журам баримтална.

3.2. Гэр хорооллын өрхүүдэд тавигдах шаардлагууд:

- 3.2.1. Өөрийн хашааны 20%-д ногоон орчин бүрдүүлсэн байх
- 3.2.2. Хашааны гэрэлтүүлэг, хаягжилт, шуудангийн хайрцагтай байх
- 3.2.3. Хашаандaa эрүүл ахуйн стандарт хангасан бие засах газар, муу усны нүхтэй байх, түүнийгээ сард 1 удаа ариутгаж хэвшсэн байх

- 3.2.4. Хашааны ойр орчим хог хаягдалгүй байлгах тал дээр анхаарч цэвэр цэмцгэр орчин бүрдүүлэхэд идэвх санаачлагатай оролцсон байх
- 3.2.5. Хашаагаа жигд /оохордож/ өнгө үзэмжтэй болгосон байх
- 3.2.6. Гэрийн тэжээвэр амьтан /нохой, муур/-аа гэрчилгээжүүлж, уяж малладаг, мал эмнэлгийн үйлчилгээнд хамруулан ИТХ-аар батлуулсан журмын дагуу хураамжийг жил бүр төлж хэвшсэн байх,
- 3.2.7. ЗДТГ болон бусад байгууллагуудаас зохион байгуулсан олон нийтийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог байх
- 3.2.8. Мал сүрэг өвчин эмгэггүй байх.

3.3. Хөдөөгийн айл өрхүүдэд тавигдах шаардлагууд:

- 3.3.1. Өвөлжөө хаваржааны орчмоо тохижуулж, хөрзөнгөө хаврын улиралд ховхолж, ариутгал халдвартгүйтгэл хийсэн байх
- 3.3.2. Худаг булгийн эхийг хамгаалж тохижуулан горхи, голын голдиргын орчмын хогийг цэвэрлэж бохирдолгүй болгосон байх
- 3.3.3. Зуслан, намаржааны газраа сар бүр тогтмол цэвэрлэдэг байх
- 3.3.4. Гэрийн тэжээвэр амьтан /нохой, муур/-аа гэрчилгээжүүлж, уяж малладаг, мал эмнэлгийн үйлчилгээнд хамруулан ИТХ-аар батлуулсан журмын дагуу хураамжийг жил бүр төлж хэвшсэн байх,
- 3.3.5. ЗДТГ болон бусад байгууллагуудаас зохион байгуулсан олон нийтийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог байх
- 3.3.6. Мал сүрэг өвчин эмгэггүй байх
- 3.3.7. Ойр орчим хог хаягдалгүй байлгах тал дээр анхаарч цэвэр цэмцгэр орчин бүрдүүлэхэд идэвх санаачлагатай оролцсон байх

3.4. Орон сууц хорооллын орцуудад тавигдах шаардлагууд:

- 3.4.1. Орцны бүх өрх айл хаалганы дугаар /номер/-той байх
- 3.4.2. Айл өрх бүр нь гэрийн хаалга нь хонхтой байх
- 3.4.3. Шуудангийн хайрцагтай байх
- 3.4.4. Орцны дотор болон гадна хаалгатай байх
- 3.4.5. Орцны дотор болон гадна гэрэл, гэрэлтүүлэгтэй байх
- 3.4.6. Орцны шат бариул, хана таазыг засаж өнгө үзэмжийг дээшлүүлэн доторх тохижилтыг сайжруулсан байх
- 3.4.7. Орцны ойр орчим хог хаягдалгүй байлгах тал дээр анхаарч цэвэр цэмцгэр орчин бүрдүүлэхэд нэг ажил санаачлан хэвшүүлсэн байх
- 3.4.8. Байрны гадна талын өнгө үзэмжийг сайжруулсан байх.
- 3.4.9. ЗДТГ болон бусад байгууллагуудаас зохион байгуулсан олон нийтийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог байх

Дөрөв. Шалгуурт оролцогчдын бүрдүүлэх материалууд:

- 4.1. Багийн Засаг даргын тодорхойлолт
- 4.2. Өрхийн тэргүүний цахим үнэмлэхний хуулбар
- 4.3. Тухайн жилд хийж хэрэгжүүлж хэвшил болгосон ажил түүнийг нотлох баримт материал, тайланг зурагжуулж ирүүлнэ.

Тав. Урамшуулах ажлын зохион байгуулалт

5.1. Энэ журамд заасан шалгуур үзүүлэлтийн дагуу материалыг бүрдүүлж жил бүрийн 12 дугаар сарын 15-ны дотор багийн Засаг дарга нар ЗДТГ-н Нийгмийн бодлого хариуцсан мэргэжилтэнд өгөх ба шаардлага хангаагүй материалыг хүлээн авахгүй болно.

5.2. Сумын Засаг даргын зөвлөлийн хурлаар ирүүлсэн материалыг хянан үзэж шаардлагатай бол газар дээр нь танилцсаны үндсэн дээр шалгаруулж шийдвэр гаргуулна.

5.3. Оны Шилдэг Соёлч өрх, орцын шагналыг жил бүр сумын “Шинэ жилийн баяр”-ын үеэр гардуулна.

Зургаа. Урамшууллын хэлбэр

6.1.Орон сууц, гэр хороолол, хөдөөгийн өрхүүдэд тавигдах шалгуур үзүүлэлтийг хангасан “Соёлч өрх, орц”-ыг Сумын Засаг даргын батламжилсан өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулна.

6.2.Оны Шилдэг Соёлч өрх-орцын талаарх мэдээллийг Орхонтуул сүм, Рашаант тосгоны албан ёсны вэб сайт, “Орхонтуул ЗДТГ” фасебоок хаяг болон “Орхонтуулын мэдээ” сонинд нийтэлж олон нийтэд мэдээлнэ.

6.3. Шилдэг Соёлч өрхүүдийн гэр бүлийн зураг болон Соёлч орцын бүх өрхүүдийн нэгдсэн байдлаар даруулсан зургийг “Хүндэт самбар”-т жилийн турш байрлуулж алдаршуулна.

6.4.Энэ журмын дагуу олгох урамшуулалттай холбогдсон зардлыг сумын Засаг даргын нөөц сангаас гаргана.

-----оо-----